



**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-44-44, Факс: (976-11) 32-90-84,  
E-mail: info@frc.mn, http://www.frc.mn

2022.01.05 № 11/43  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ,  
ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН  
ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧ  
НЭР БҮХИЙ 40 КОМПАНИ-Д

**Мэдэгдэл хүргүүлэх тухай**

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Санхүүгийн зохицуулах хороо нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих...” гэж заасны дагуу дараах хууль тогтоомжийн биелэлтийг хангаж ажиллахыг үүрэг болгож байна. Үүнд:

1. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.6-д заасны дагуу дүрс бичлэгийн техник, хэрэгсэл суурилуулж, энэ талаар Цагдаагийн байгууллагын саналыг Хороонд цахим шуудан/dpms@frc.mn/-аар ирүүлэх;

2. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасны дагуу 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын таван өдрийн дотор, сэжигтэй гүйлгээг 24 цагийн дотор батлагдсан маягт, журмын дагуу Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх;

3. Мөн хуульд заасанчлан мэдээлэх үүрэгтэй этгээд нь харилцагчийг албан ёсны эх сурвалж, баримт бичиг, мэдээ, мэдээллийн эх үүсвэр ашиглан таньж мэдэх үүргээ биелүүлэх;

4. Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д заасны дагуу бараа, ажил, үйлчилгээний үнийг Монгол Улсын нутаг дэвсгэрт зөвхөн үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлж, түүгээр төлбөр тооцоог гүйцэтгэх, Монголбанкны албан ёсны зөвшөөрөлгүйгээр гадаад валют, тооцооны нэгжээр үнэ тогтоох, төлбөр тооцоог гүйцэтгэх, зарлан сурталчлахгүй байх;

5. Хуулийн этгээдийн Улсын бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4-т заасны дагуу эрх бүхий төрийн байгууллагаас зөвшөөрөл авч бүртгүүлдэг өөрчлөлтийн хувьд тухайн байгууллагын зөвшөөрөл олгосон шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш тухайн хуулийн этгээд ажлын 15 өдрийн дотор улсын бүртгэлийн байгууллагад хүргүүлэх үүрэгтэй;

6. Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 211 дүгээр тогтоолоор баталсан “Зохицуулалтын үйлчилгээний хөлсийг төвлөрүүлэх журам”-д заасны дагуу зохицуулалтын үйлчилгээний хөлсийг жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Төрийн сан банк, СЗХ-ны 100900025001 тоот дансанд төвлөрүүлсэн байх;

7. Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 150 дугаар тогтоолоор баталсан “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олголт, бүртгэлийн журам”-ын 2.5.6-д заасны дагуу Хорооноос баталсан

151830000096

сургалтын хөтөлбөрийн дагуу Холбооноос зохион байгуулагдсан сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцсэн сертификатын хуулбарыг Хороонд цахим шуудан/dpms@frc.mn/-аар ирүүлэх;

8. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч хуулийн этгээд нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах, салбар нээн ажиллуулах, хуулийн этгээдийн оноосон нэрийг өөрчлөх тохиолдолд тухай бүр Хорооноос олгосон зөвшөөрлийн хүрээнд хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлэх;

9. Мөн арилжаа эрхлэгч хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан/гүйцэтгэх захирал, комплаенсын ажилтан/ өөрчлөгдөх, ажлын байрны болон салбарын хаяг байршлын өөрчлөлтийг тухай бүр Хороонд мэдэгдэж, нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн байх;

10. Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 182 дугаар тогтоолоор баталсан “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам”-ын 4.1-д заасны дагуу эхний хагас жилийн тайланг 7 дугаар сарын 20-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор Хороонд цахимаар болон албан бичгээр ирүүлэх, мөн 4.3.1-4.3.5-д заасан мэдээг сар бүр гаргаж, дараа сарын 10-ны өдрийн дотор Хороонд цахимаар ирүүлэх зэрэг болно.

Өгсөн үүрэг даалгаврыг хүлээн авсан болон биелүүлж ажилласан талаарх тайлбар, холбогдох баримт бичгийг 2022 оны 1 дүгээр улиралдаа багтаан Хороонд албан тоотоор ирүүлэхийг үүгээр мэдэгдье.

ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛ,  
ҮНЭТ ЭДЛЭЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН  
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Н.ЭНХТУЯА